ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хотын захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ДГА-2026/86/НА-СТА-ТШЗ


Цахим хуудас: www.audit.mn

Дорноговь аймаг

2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий
Утас: 70522734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр
Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Ахлах аудитор: Э.Энхцэцэг
Цахим хаяг: enkhtsetsege@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.Хараат бус аудиторын дүгнэлт

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734
Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2026.02.25 № 1-6/100

танай_____________-ны №_______________-т

САЙНШАНД СУМЫН ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ЭНХЧИМЭГ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сайншанд сумын хотын захирагчийн ажлын албаны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Сайншанд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 03/04 “Сайншанд тохижилт үйлчилгээний орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын нэр, хуулийн этгээдийн хэлбэрт өөрчлөлт оруулах тухай” тогтоолын дагуу хуулийн этгээдийн хэлбэрийг төрийн байгууллага, албан газар болгон өөрчилсөнтэй холбоотой Сайншанд сумын хотын Захирагчийн ажлын албыг байгуулж, сумын Засаг даргын 2025 оны 1 дүгээр сарын 02-ны өдрийн А/03 захирамжаар тус албаны бүтэц орон тоог 8 ажилтантайгаар шинэчлэн баталсан байна.

**Аудитын гол асуудал**

Тус байгууллагын бүтэц өөрчлөгдсөнтэй холбоотой Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 07/02, Сайншанд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 04/07 тогтоолын дагуу тайлант хугацаанд 245,728,155.14 төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, 15,115,465,984.9 төгрөгийн хөрөнгө болон 799,081,785.68 төгрөгийн бараа материалыг шилжүүлэн, нийт 16,160,275,925.72 төгрөгийн эргэлтийн хөрөнгийг шилжүүлэн бүртгэж, санхүүгийн тайланд тусгаж тайлагнасан байна.

Мөн тус байгууллагын санхүүгийн тайлгийн бусад өглөгийн дансанд тусгагдсан 1,984,285 төгрөгийн өглөг нь Сайншанд тохижилт үйлчилгээний газартай холбоотой үүссэн байх тул аудитын явцад холбогдох байгууллагын тайланд залруулан тусгуулсан болно.

**Бусад асуудлын хэсэг**

442505051

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд бусад асуудлын хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.ГАН-ӨЛЗИЙ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **812,728,397.99** | **23,432,157.02** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 2,252,481.00 | - |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 2,252,481.00 | - |
| **3121** | **Төгрөг** | 2,252,481.00 | - |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 2,252,481.00 | - |
| **33** | **АВЛАГА** | 7,796,831.31 | 18,228,657.02 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 428,339.31 | 5,468,305.02 |
| **335** | **Бусад авлага** | 7,368,492.00 | 12,760,352.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 7,368,492.00 | 12,760,352.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 802,679,085.68 | 5,203,500.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 802,679,085.68 | 5,203,500.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 4,062,200.00 | 1,821,900.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 750,825,025.68 | 3,381,600.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 47,165,860.00 | - |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 623,500.00 | - |
| 35460 | Хүнсний материал | 2,500.00 | - |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **8,799,916,420.46** | **274,802,077.26** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 8,799,916,420.46 | 274,802,077.26 |
| **392** | **Биет хөрөнгө** | 8,786,586,420.33 | 274,802,077.26 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 418,496,248.00 | - |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (106,695,011.27) | - |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 3,197,136,816.00 | 571,295,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (1,673,982,614.51) | (315,169,166.71) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 114,727,730.00 | 31,412,000.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (33,268,560.14) | (16,467,741.82) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 31,216,842.00 | 7,505,562.76 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (10,930,034.73) | (3,773,576.97) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 12,194,999,836.04 | 11,870,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (5,345,114,831.06) | (11,870,000.00) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 13,330,000.13 | - |
| 39301 | Програм хангамж | 2,299,000.00 | 1,727,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (2,232,999.87) | (1,727,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 13,264,000.00 | - |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **9,612,644,818.45** | **298,234,234.28** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **15,242,675.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | 15,242,675.00 |
| **413** | **Өглөг** | - | 15,242,675.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | 116,500.00 |
| **4136** | **Бусад өглөг** | - | 15,126,175.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 1,773,200.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | 13,352,975.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **9,612,644,818.45** | **282,991,559.28** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 9,612,644,818.45 | 282,991,559.28 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 2,313,537,678.87 | 2,313,537,678.87 |
| 51101 | Өмч: - төрийн | 2,313,537,678.87 | 2,313,537,678.87 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 7,130,336,482.02 | (2,036,358,714.58) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 7,130,336,482.02 | 7,291,042,063.59 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (9,327,400,778.17) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 168,770,657.56 | 5,812,594.99 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **9,612,644,818.45** | **298,234,234.28** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **10,364,864,601.37** | **352,148,966.20** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **5,798,136,273.21** | **12,876,316.20** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 5,798,136,273.21 | 12,876,316.20 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 34,920,411.00 | 12,203,643.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 34,920,411.00 | 12,203,643.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 5,545,518,178.89 | 672,673.20 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | 217,697,683.32 | |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **4,566,728,328.16** | **339,272,650.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 35,628,600.00 | 28,766,050.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 35,628,600.00 | 28,766,050.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 4,531,099,728.16 | 310,506,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 4,531,099,728.16 | 310,506,600.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **6,394,818,064.93** | **1,236,905,860.67** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **6,394,818,064.93** | **1,236,905,860.67** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 6,394,818,064.93 | 1,211,021,255.45 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 2,872,850,436.07 | 255,423,241.16 |
| 210101 | Үндсэн цалин | 1,033,075,229.25 | 145,953,877.83 |
| 210102 | Нэмэгдэл | 1,359,310,200.82 | 66,346,363.33 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 353,444,132.00 | 24,460,000.00 |
| 210104 | Урамшуулал | 127,020,874.00 | 18,663,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 394,430,290.00 | 31,707,630.91 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 256,631,051.00 | 21,897,558.93 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 35,467,539.00 | 2,328,854.10 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 28,937,600.00 | 1,164,425.68 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 11,712,400.00 | 1,164,425.68 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 61,681,700.00 | 5,152,366.52 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 27,539,443.23 | - |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,680,649.53 | - |
| 210302 | Түлш, халаалт | 24,300,225.70 | - |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,558,568.00 | - |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 494,963,600.00 | 803,192,885.68 |
| 210401 | Бичиг хэрэг | 17,003,820.00 | 3,447,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 122,089,200.00 | 630,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,998,400.00 | 33,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 345,654,700.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8,217,480.00 | - |
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | 799,081,785.68 |
| **2105** | **Нормативт зардал** | 354,397.00 | - |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 90,934.00 | - |
| 210502 | Хоол, хүнс | 263,463.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 443,616,301.20 | - |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 143,000.00 | - |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 36,182,972.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 407,290,329.20 | - |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 80,000.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 80,000.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 367,689,240.86 | 23,012,825.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 355,609,863.86 | 23,012,825.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 10,000,000.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 434,757.00 | - |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 750,000.00 | - |
| 210807 | Газрын төлбөр | 394,620.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,793,294,356.57 | 97,684,672.70 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 2,466,540.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,320,000.00 | 650,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 1,791,974,356.57 | 94,568,132.70 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | 25,884,605.22 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 25,884,605.22 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 25,884,605.22 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **3,970,046,536.44** | **(884,756,894.47)** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 9,011,428.53 | 8,442,643,883.70 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 9,011,428.53 | - |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | | 8,442,643,883.70 |

| | | | |
|---|---|---|---|
| 4 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (9,011,428.53) | (8,442,643,883.70) |
| 5 | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **3,961,035,107.91** | **(9,327,400,778.17)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **4,601,648,739.16** | **358,844,785.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **34,920,411.00** | **12,203,643.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 34,920,411.00 | 12,203,643.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 34,920,411.00 | 12,203,643.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 34,920,411.00 | 12,203,643.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **4,566,728,328.16** | **346,641,142.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 35,628,600.00 | 36,134,542.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 35,628,600.00 | 36,134,542.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 4,531,099,728.16 | 310,506,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 4,531,099,728.16 | 310,506,600.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **4,557,325,245.16** | **347,419,785.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **4,557,325,245.16** | **347,419,785.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **4,549,956,753.16** | **308,774,827.78** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 2,865,258,329.07 | 259,402,586.13 |
| 210101 | Үндсэн цалин | 1,016,174,477.50 | 149,933,222.80 |
| 210102 | Нэмэгдэл | 1,445,084,934.57 | 66,346,363.33 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 287,900,203.00 | 24,460,000.00 |
| 210104 | Урамшуулал | 116,098,714.00 | 18,663,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 396,499,700.00 | 32,768,251.65 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 259,917,800.00 | 22,618,782.71 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 34,250,200.00 | 2,413,701.26 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 28,937,600.00 | 1,206,850.48 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 11,712,400.00 | 1,206,850.68 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 61,681,700.00 | 5,322,066.52 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 26,364,793.70 | - |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 506,000.00 | - |
| 210302 | Түлш, халаалт | 24,300,225.70 | - |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,558,568.00 | - |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 469,496,334.00 | 2,672,600.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,499,000.00 | 2,125,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 193,579,000.00 | 530,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,998,400.00 | 16,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 265,428,400.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,991,534.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | 69,898,400.00 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 69,898,400.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 293,330,880.00 | - |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 9,752,580.00 | - |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 15,498,840.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 268,079,460.00 | - |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 80,000.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 80,000.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 426,887,616.39 | 10,174,350.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 414,796,739.39 | 10,174,350.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 10,000,000.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 446,257.00 | - |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 750,000.00 | - |
| 210807 | Газрын төлбөр | 394,620.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,140,700.00 | 3,757,040.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 3,757,040.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,140,700.00 | - |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **7,368,492.00** | **38,644,957.22** |

| | | | |
|---|---|---|---|
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 7,368,492.00 | 38,644,957.22 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 25,884,605.22 |
| 213405 | Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг | 7,368,492.00 | 12,760,352.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **44,323,494.00** | **11,425,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **37,225,600.00** | **11,425,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **37,225,600.00** | **11,425,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 37,225,600.00 | 11,425,000.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 31,273,750.00 | 11,425,000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 5,951,850.00 | - |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(44,323,494.00)** | **(11,425,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 10,350,375.00 | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| D01 | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **2,313,537,678.87** | **168,770,657.56** | **7,130,336,482.02** | 9,612,644,818.45 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 160,705,581.57 | 160,705,581.57 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **2,313,537,678.87** | **168,770,657.56** | **7,291,042,063.59** | 9,773,350,400.02 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | (162,958,062.57) | - | (162,958,062.57) |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (9,327,400,778.17) | (9,327,400,778.17) |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,313,537,678.87** | **5,812,594.99** | **(2,036,358,714.58)** | 282,991,559.28 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Хэтрэлт, хэмнэлт | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 358,448,100.00 | 296,825,637.78 | 61,622,462.22 | 82.8 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 358,448,100.00 | 296,825,637.78 | 61,622,462.22 | 82.8 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 358,448,100.00 | 296,825,637.78 | 61,622,462.22 | 82.8 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 304,054,100.00 | 259,402,586.13 | 44,651,513.87 | 85.3 |
| 210101 | Үндсэн цалин | 172,000,000.00 | 149,933,222.80 | 22,066,777.20 | 87.2 |
| 210102 | Нэмэгдэл | 80,064,100.00 | 66,346,363.33 | 13,717,736.67 | 82.9 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 27,040,000.00 | 24,460,000.00 | 2,580,000.00 | 90.5 |
| 210104 | Урамшуулал | 24,950,000.00 | 18,663,000.00 | 6,287,000.00 | 74.8 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 37,988,100.00 | 32,768,251.65 | 5,219,848.35 | 86.3 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 25,825,900.00 | 22,618,782.71 | 3,207,117.29 | 87.6 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,040,500.00 | 2,413,701.26 | 626,798.74 | 79.4 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,520,300.00 | 1,206,850.48 | 313,449.52 | 79.4 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,520,300.00 | 1,206,850.68 | 313,449.32 | 79.4 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,081,100.00 | 5,322,066.52 | 759,033.48 | 87.5 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 5,277,500.00 | 2,672,600.00 | 2,604,900.00 | 50.6 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210401 | Бичиг хэрэг | 3,857,500.00 | 2,125,700.00 | 1,731,800.00 | 55.1 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,120,000.00 | 530,400.00 | 589,600.00 | 47.4 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 300,000.00 | 16,500.00 | 283,500.00 | 5.5 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 11,128,400.00 | 1,982,200.00 | 9,146,200.00 | 17.8 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 9,026,000.00 | 1,982,200.00 | 7,043,800.00 | 22.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,365,200.00 | - | 1,365,200.00 | 0.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 287,000.00 | - | 287,000.00 | 0.0 |
| 210807 | Газрын төлбөр | 450,200.00 | - | 450,200.00 | 0.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 358,448,100.00 | 322,710,243.00 | 35,737,857.00 | 90.0 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 343,448,100.00 | 310,506,600.00 | 32,941,500.00 | 90.4 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 343,448,100.00 | 310,506,600.00 | 32,941,500.00 | 90.4 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 15,000,000.00 | 12,203,643.00 | 2,796,357.00 | 81.4 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 15,000,000.00 | 12,203,643.00 | 2,796,357.00 | 81.4 |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | - | **23,374,190.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | - | **11,949,190.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | - | 11,949,190.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | - | 8,192,150.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 8,192,150.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | - | 3,757,040.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 3,757,040.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | - | **11,425,000.00** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | - | 11,425,000.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 11,425,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | - | 36,134,542.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 36,134,542.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 36,134,542.00 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 828,060.5 мянган төгрөгийн 2 алдаа илрүүлж, аудитын явцад залруулсан.

### 3.1. Залруулсан алдаа

1. 2025 оны хагас жилийн санхүүгийн тайлангийн СТ-2А, СТ-3А тайлангийн нэмэлт санхүүжилтийн орлого 11.4 сая төгрөгийн орлогыг тусгаагүй, Сайншанд Тохижилтын газарт балансаас шилжүүлсэн 798.0 сая төгрөгийн бараа материалыг зардалд хүлээн зөвшөөрч бүртгээгүй, мөн ахмадын сангийн оны эхний үлдэгдэл 2.2 сая төгрөгийг үлдэгдлээр тайланд тусгасныг завсрын аудитаар залруулсан.

   Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 *“Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг баримтална”, 18 дугаар зүйлийн* 18.1 “*Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ*”, 20 дугаар зүйлийн 20.2.6 “*Ерөнхий нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан*

*авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах үүрэг хүлээнэ*" гэсэн заалттай нийцэхгүй байна.

**2.** Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөөг 8.8 сая төгрөг, авлагын үлдэгдлийг 5.5 сая төгрөг, өглөгийг 2.0 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй илэрхийлснийг санхүүгийн байдлын тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд залруулсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 *"Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг баримтална",* 20 дугаар зүйлийн 20.2.6 "*Ерөнхий нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах үүрэг хүлээнэ*" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Аудитаар нийт 3 зөрчил илрүүлж, 1 албан шаардлага, 2 зөвлөмжийг хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин болох 3.6 сая төгрөгөөс бага байх тул "Өөрчлөлтгүй дүгнэлт" өглөө.

### 3.2. Албан шаардлага

1. Захиалагчийн хяналтын зардлаас холбогдох журмын заалтыг зөрчиж 10.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 "*Төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих бүрэн эрхийг хэрэгжүүлнэ*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "*Ерөнхий нягтлан бодогч нь ... дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах"* гэсэн заалттай нийцэхгүй байна.

### 3.3. Зөвлөмж

***1. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал.***

***1.1 Илрүүлэлт****:* Албан хаагчдын цалин, нэмэгдэл хөлсийг тогтоохдоо холбогдох хууль, журмын заалтын дагуу шийдвэрлээгүй байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 "*Хуульд өөрөөр заагаагүй бол доор дурдсан төрийн захиргааны албан тушаалд энэ хуулийн 22.1-д заасан нийтлэг шаардлагаас гадна дараах тусгай шаардлагыг хангасан иргэнийг томилно*" гэж заасантай нийцэхгүй байна.

*1.2* ***Өгсөн зөвлөмж:*** Албан хаагчдын цалин, нэмэгдэл хөлсийг холбогдох хууль, журмын заалтын дагуу тогтоож цалинжуулах.

***2. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал.***

*2.1* ***Илрүүлэлт:*** Туслах үйл ажиллагааны орлогыг 2025 онд 15.0 сая төгрөгөөр баталж, 2.3 сая төгрөгийг төвлөрүүлсэн ба тус орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж тайлагнасан. Мөн захиалагчийн хяналтын зардлыг туслах үйл ажиллагааны орлогод буруу тусгаж тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2 "*Энэ хуулийн 5.1.1-д заасан төсвийн тогтвортой байдлыг хангасан байх зарчмыг жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн батлаж, хэрэгжүүлэх*" гэж заасантай нийцэхгүй байна.

2.2 ***Өгсөн зөвлөмж:*** Туслах үйл ажиллагааны орлогыг бодит нөхцөл байдалтай уялдуулан тооцон, төлөвлөж батлуулах, үнэн зөв тайлагнах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулса | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 2025 оны хагас жилийн санхүүгийн тайланд нэмэлт санхүүжилтийн орлого, шилжүүлсэн БМ, ахмадын сангийн харилцах дансны үлдэгдлийг зөрүүтэй тусгасан. | 1 | 811,696.0 | - | - | 1 | 811,696.0 | 1 | 811,696.0 | - | - |
| Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөөг 8.8 сая төгрөг, авлагыг 5.5 сая төгрөг, өглөгийг 2.0 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн | 1 | 16,364.5 | - | - | 1 | 16,364.5 | 1 | 16,364.5 | - | - |
| **Дүн** | **2** | **828,060.5** | **-** | **-** | **2** | **828,060.5** | **2** | **828,060.5** | - | - |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Албан хаагчдын цалин, нэмэгдэл хөлсийг холбогдох хууль, журмын заалтыг үндэслэж шийдвэрлээгүй. | 1 | - | - | - | - | - | 1 | - |
| Туслах үйл ажиллагааны орлогыг 2025 онд 15.0 сая төгрөгөөр баталж, 2.3 сая төгрөгийг төвлөрүүлсэн ба тус орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн, мөн захиалагчийн хяналтын зардлыг туслах үйл ажиллагааны орлогод буруу тусгаж тайлагнасан. | 1 | - | - | - | - | - | 1 | - |
| Захиалагчийн хяналтын зардлаас холбогдох журмыг зөрчиж 10.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан. | 1 | - | - | - | 1 | - | - | - |
| **Дүн** | **3** | **-** | **-** | **-** | **1** | **-** | **2** | **-** |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.